



ТӨВ АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ 2023 ОНЫ 02 САРД
БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТАНИЛЦУУЛГА


2023.03.05

Зуунмод сум


**НЭГ. ДУУДЛАГА МЭДЭЭЛЭЛ, ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛИЙН
ШИНЖТЭЙ ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ**

Тус Цагдаагийн газарт 2023 оны 02 дугаар сард нийт 705 дуудлага мэдээлэл хүлээн авсныг урьд оны мөн үетэй харьцуулахад -7 дуудлага мэдээллээр буюу 0,9 хувиар буурсан байна. /Урьд онд 712/

Дуудлага мэдээллийг төрлөөр нь харуулбал:



Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 550 гомдол мэдээлэл хүлээн авсан, өмнөх үлдэгдэл гомдол 34, нийт 584 гомдол мэдээлэл шалгаснаас хуулийн хугацаанд 499 буюу 85,4 хувийг шийдвэрлэсэн байна. /Үлдэгдэл 85/
Бүртгэгдсэн гомдол, мэдээллийг өнгөөр нь авч үзвэл:



Үүнээс гэмт хэргийн шинжтэй 238 гомдол хүлээн авснаас 194 буюу 81,5 хувийг шийдвэрлэж, 44 гомдлын үлдэгдэлтэй байна. Шийдвэрлэсэн байдлыг авч үзвэл:


- Хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 62 буюу 31,9 хувь
- Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 132 буюу 68 хувь
- Харьяаллын дагуу шилжүүлсэн-0

Гэмт хэргийн шинжтэй нийт шийдвэрлэсэн 194 гомдол мэдээллийн 139 буюу 71,6 хувийг 5 хоногт, 54 буюу 27,8 хувийг 6-19 хоногт шийдвэрлэсэн байна. 20 ба түүнээс дээш хоногоор шийдвэрлэсэн гомдол мэдээлэл 4 байна.

ХОЁР. БҮРТГЭГДСЭН ГЭМТ ХЭРЭГ, ТҮҮНИЙ ХӨДӨЛГӨӨН

2023 оны 02 сард 132 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад - 17 нэгжээр буюу -11,4 хувиар буурсан, хэрэг бүртгэлтийн 104 хэрэг бүртгэгдсэний 34 хэргийг илрүүлж, илрүүлэлт 32,7 хувьтай, өмнөх оны мөн үетэй харьцуулахад илрүүлэлт ижил түвшинд байна.

Сумдад бүртгэгдсэн хэрэг:




Бүртгэгдсэн гэмт хэргийг урьд оны мөн үетэй харьцуулахад:

Заамар 11

Сэргэлэн 2

Батсүмбэр-2 нэгжээр тус тус өссөн байна.

Бүртгэгдсэн хэрэг /өнгөөр/:



Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 63 бүртгэгдсэн 11 буюу 21,1 хувь хувиар, залилах гэмт хэрэг 25 гарсан 3 нэгжээр буюу 8,6 хувиар тус тус өссөн байна. Хулгайлах гэмт хэрэг 25 бүртгэгдсэн нь 6 нэгжээр буюу 31,5 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 50 тус тус өссөн,

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 5 нэгжээр буюу -71,4 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 45 бүртгэгдсэн нь -5 хэргээр буюу -10 хувь,


хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг -14,2 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7 бүртгэгдсэн нь -56,2 хувиар тус тус буурсан.

Нийт гэмт бүртгэгдсэн гэмт хэргийн 47 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 34 хувийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 18,9 хувийг залилах гэмт хэрэг эзэлж байна.

Хэргийн гаралт, илрүүлэлт:

Д/д	Үзүүлэлт	2022 он	2023 он	Өсөлт, бууралт	
				Тоогоор	Хувиар
1	Нийт бүртгэгдсэн гэмт хэрэг	149	132	-17	-11,4
2	Хэрэг бүртгэлтийн хэрэг	110	104	-6	-5,5
3	Үүнээс: Илэрсэн хэрэг	36	34		
4	Илрүүлэлтийн хувь	32,7	32,7	0+	

Гэмт хэргийн илрүүлэлт төвийн бүсийн аймгуудтай харьцуулахад



Гэмт хэрэг үйлдэгдсэн байдал:

Үзүүлэлт	2022 он	2023 он	Өсөлт бууралт /%-р/
Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг	6	8	2 нэгжээр буюу 33,3%+

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг	36	17	-19 нэгжээр буюу -52,7%
Хүүхэд оролцсон гэмт хэрэг	2	3	1 нэгжээр буюу 50%+
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн хэрэг	10	6	-4 нэгжээр буюу 40%-
Бүлгээр үйлдэгдсэн хэрэг	5	3	-2 нэгжээр буюу 40%-

Гэмт хэргийн улмаас хохирсон хүний тоо 122 байгаагаас эмэгтэй хүн 36, хүүхэд 9 байна.


2023 оны 02 сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад 2 тэрбум 442 сая төгрөгийн хохирол учирч үүнээс 242,2 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлж, хохирол нөхөн төлүүлэлт 8,5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад -25,7 хувиар буурсан байна. /Урьд онд 34,2%/

Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг, цаг хугацаагаар нь авч үзвэл:

Огноо	Нийт хэрэг	Гэмт хэрэг үйлдэгдсэн гараг							Хэрэг үйлдэгдсэн цаг			
		даваа	мягмар	лхагва	пүрэв	баасан	бямба	ням	06-14	14-19	19-22	22-06
2023 оны 02 сар	132	19	22	9	24	21	20	17	33	34	29	36

2023 оны 02 дугаар сард Мягмар, Пүрэв, Баасан, гаригт хамгийн их буюу 67 гэмт хэрэг нийт гэмт хэргийн 50,7 хувь нь бүртгэгдсэн байна.

Гэмт хэрэг үйлдэгдсэн газраар нь харьцуулан авч үзвэл:




Бүртгэгдсэн гэмт хэргээс гэр орон сууцанд 39 буюу 29,5 хувийг, гудамж талбайд 8 буюу 6 хувийг, олон нийтийн газар 6 буюу 4,5 хувийг, аж ахуй нэгж 4 буюу 3 хувийг, бусад газар 69 буюу 52,2 хувийг, авто замд 5 буюу 3,7 хувь нь тус тус үйлдэгдсэн байна.

ГУРАВ: ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ДУУДЛАГА МЭДЭЭЛЭЛ, ЗӨРЧЛИЙН ШИНЖТЭЙ ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ, ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ


Тус Цагдаагийн газарт 2023 оны 02 сард өссөн дүнгээр 484 дуудлага мэдээлэл хүлээн авсныг урьд оны мөн үетэй харьцуулахад -9 дуудлага мэдээллээр буюу -1,8 хувиар буурсан байна. /Урьд онд 493/

Дуудлага мэдээллийг төрлөөр нь харуулбал:




Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлт:

Зөрчлийн шинжтэй нийт 346 гомдлыг хүлээн авч 305 буюу 88,1 хувийг нь шийдвэрлэж 41 гомдлын үлдэгдэлтэй байна. Шийдвэрлэлтийн байдлыг авч үзвэл:




Хүлээн авсан захиргааны зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн шийдвэрлэлтийг хугацаагаар нь харуулбал;



Тус Цагдаагийн газарт нийт 15505 зөрчил хүлээн авснаас 15455 буюу 99,6 хувийг шийдвэрлэсэн ба урьд оны мөн үетэй харьцуулахад хүлээн авсан зөрчил 5830 буюу 60,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. /Урьд онд 9675/

Зөрчлийг төвийн бүсийн аймгуудын цагдаагийн газар хэлтсүүдтэй




харьцуулбал:


Нийт шалгасан зөрчлөөрөө **1 дүгээр байрт** орсон байна.

2023 оны 02 сард ердийн журмаар шийдвэрлэсэн нийт 15184 зөрчил бүртгэгдсэн нь нийт шийдвэрлэсэн зөрчлийн 97,9 хувийг эзэлж байна.

Зөрчлийн хэрэг нээсэн болон хялбаршуулсан зөрчил




Зөрчлийн шийдвэрлэлт:




- 47 иргэнийг баривчилж,
- 133 иргэнийг торгож, эрх хасах шийтгэл ногдуулсан.

Төв аймгийн хэмжээнд баривчлагдсан хүн -49хувиар, торгож, эрх хассан хүн -53,8 хувиар буурсан байна.

Зөрчлийг хэрэг нээж, шүүхээр баривчлуулсан байдлыг бусад төвийн бүсийн Аймгуудын Цагдаагийн газар хэлтэстэй харьцуулахад:




Зөрчил үйлдэгдсэн газар, зөрчлийн тоо:



Нийт бүртгэгдсэн зөрчлийн гэр орон сууцанд 44 буюу 20,5 хувь, гудамж талбайд 54 буюу 25,2 хувь, зам дээр үйлдэгдсэн 205 буюу 97,5 хувь тус тус үйлдэгдсэн байна.


Зөрчил үйлдэгдсэн газраар нь харьцуулан үзэхэд зам, гэр орон сууцанд, гудамж талбайд хамгийн ихээр үйлдэгдсэн байна.

Зөрчлийн үйлдэгдсэн гараг нь:




Бүртгэгдсэн нийт зөрчлийн 2153 буюу 13,8 хувь нь даваа гаригт, 2470 буюу 15,9 хувь нь мягмар гаригт, 2435 буюу 17,5 хувь лхагва гаригт, 2222 буюу 14,3 хувь нь пүрэв гаригт, 2328 буюу 15 хувь нь баасан гаригт, 1948 буюу 12,5 хувь нь бямба гаригт, 1949 буюу 12,5 хувь нь ням гаригт тус бүр үйлдэгдсэн байна.

Зөрчил үйлдэгдсэн цаг хугацаа нь:



Бүртгэгдсэн нийт 57821 захиргааны зөрчлийн үйлдэгдсэн цаг: 06-12 цагт 2440 буюу 15,7 хувь, 13-18 цагт 9482 буюу 61,1 хувь, 19-24 цагт 3275 буюу 21,1 хувь, 01-05 цагт 305 буюу 1,9 хувь нь үйлдэгдсэн байна.

Зөрчил үйлдэгдсэн онцлог:



ДӨРӨВ: ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЧИГЛЭЛЭЭР:

Аймаг орон нутгаас тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор “Цахим орчны хяналтыг сайжруулъя” аяны хүрээнд 11 видео Шторк, 7 постер мэдээллийг пэйж хуудсанд байршуулсан. Төв аймгийн Засаг даргын тамгын ажилтан алба хаагч нарт “Гэмт хэрэг зөрчлийн хор уршиг, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам” сэдвээр сургалт зохион байгуулан ажилласан.

Төв аймгийн 27 сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Засаг дарга нарт 2022 онд аймаг болон тухайн суманд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээлэл, цаашид урьдчилан сэргийлэх чиглэлээр хийх ажлын талаарх зөвлөмжийг хүргүүлсэн.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд 2023 оны гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөө, шаарлдагатай тоног төхөөрөмжийн төслийг хүргүүлсэн ажилласан байна.

ТАВ: ДҮГНЭЛТ:

Гэмт хэргийн талаар: Тус цагдаагийн газарт 2023 оны 02 сард өссөн дүнгээр 132 гэмт хэрэг бүртгэгдэж хэргийн илрүүлэлт 32,7 хувьтай, улсын дундаж илрүүлэлт 30,1 хувь байна. Бүртгэгдсэн нийт гэмт хэргээс 114 буюу 86,3 хувийг хөнгөн, 18 буюу 13,6 хувийг хүнд гэмт хэрэг эзэлж, хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт 28,6 хувьтай, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 61,5 хувьтай байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулахад хөнгөн гэмт хэргийн илрүүлэлт -4,1 хувиар буурсан, хүнд гэмт хэргийн илрүүлэлт 28,2 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна.

Хохирол нөхөн төлүүлэлт 8,5 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25,7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зарим төрлийн гэмт хэргийн өсөлт бууралтын талаар: Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 63 бүртгэгдсэн 11 буюу 21,1 хувь хувиар, залилах гэмт хэрэг 25 гарсан 3 нэгжээр буюу 8,6 хувиар тус тус өссөн байна. Хулгайлах гэмт хэрэг 25 бүртгэгдсэн нь 6 нэгжээр буюу 31,5 хувиар, мал хулгайлах гэмт хэрэг 50 тус тус өссөн,

Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэн нь 5 нэгжээр буюу -71,4 хувиар, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг хэрэг 45 бүртгэгдсэн нь -5 хэргээр буюу -10 хувь,

хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг -14,2 хувиар, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7 бүртгэгдсэн нь -56,2 хувиар тус тус буурсан.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг зөрчлийн талаар: 2023 оны 02 сард хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 7 бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулахад -9 буюу -56,2 хувиар буурсан байх ба уг гэмт хэргийн улмаас 1 хүн нас барж 6 хүн гэмтсэн байна.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /14,7/ зөрчил тус аймгийн нутаг дэвсгэрт 02 сард 14056 зөрчил бүртгэгдсэн нь нийт бүртгэгдсэн зөрчил /15505/-ийн 90,6 хувийг эзэлж байна. Дээрх зөрчилд 14058 иргэнийг 408725,0 төгрөгөөр торгож 132

иргэний тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг зөрчлийн тухай хуульд зааснаар хасаж, торгосон, 11 иргэнийг шүүхийн шийтгэврээр баривчлуулж шийдвэрлүүлсэн байна.

Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг зөрчлийн талаар: 2023 оны 02 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн 1 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй ижил түвшинд байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн 35 зөрчил хүлээн авч 20 иргэнийг шүүхийн шийтгэврээр баривчлуулж шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн талаар: Аймгийн нутаг дэвсгэрт нийт 15505 зөрчил хүлээн авснаас 15455 буюу 99,8 хувийг шийдвэрлэсэн ба урьд оны мөн үетэй харьцуулахад хүлээн авсан зөрчил 2601 буюу 60,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 15275 иргэнийг шийтгэлийн хуудсаар 492594,5 төгрөгөөр торгож, 47 хүнийг шүүхээр баривчлуулсан байна. Шүүхээр баривчлуулсан хүний тоо -47 нэгжээр буюу өмнөх оноос - 50 хувиар буурсан. /урьд онд 94/ Зөрчилд нийт 271 хүн холбогдон шалгагдсанаас 4 хүүхэд, 19 эмэгтэй хүн байна. Нийгмийн байдлаар авч үзвэл 90 нь буюу 33,2 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 36 буюу 13,2 хувь нь хувийн хэвшлийн байгууллагад ажилдаг 51 буюу 18,8 хувь нь ажилчин малчин иргэд байна.

ЗУРГАА:САНАЛ

Хулгайлах гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах талаар тодорхой төрлийн арга хэмжээ зохион байгуулах.

Залилан мэхлэх гэмт хэрэг 25 бүртгэгдэж 3 нэгжээр буюу 8,6 хувиар өссөн үүнээс цахим залилангийн гэмт хэрэг 99 хувийг эзэлж байгаад дүгнэлт хийн урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх.

ТӨВ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР